



**“НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/35

Улаанбаатар хот

Хэвлэмэл хуудас хүчингүй болгох тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэг, Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолоор батлагдсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.5 дах хэсэг, “Налайхын үйлдвэрлэл, технологийн парк хаалттай хувьцаат компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.14 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Компанийн үйл ажиллагаанд хэрэглэгдэж байгаа хэвлэмэл хуудасны ашиглалт, зарцуулалтын тооцоог 2025 оны жилийн эцсийн байдлаар гаргаж, үргүй зарцуулсан хэвлэмэл хуудсыг хүчингүй болгосугай.

2.Хүчингүй болгох хэвлэмэл хуудсыг хавсралтаар баталсугай.

3.Хүчингүй болгосон хэвлэмэл хуудсанд акт үйлдэн устгалыг гүйцэтгэж, илтгэх хуудсаар танилцуулахыг Захиргааны мэргэжилтэн (Д.Номин-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

4.Хэвлэмэл хуудасны ашиглалтыг сайжруулж, үргүй зардал гаргахгүй байх, стандартын шаардлага хангасан баримт бичиг боловсруулж ажиллахыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Баримт нягтлан шалгах комиссын дарга (Н.Пүрэвсүрэн)-д даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ч.РАДНААБАЗАР